ЭРДЭНЭТ БУЛГАНЫ
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
БУЛГАН САЛБАР
Булган аймаг, Булган сум, 5-р баг,
Утас: +976 70342614
Вэб: www.edc.mn Цахим хаяг:

БАТЛАВ САЛБАРЫН ДАРГА
Г.ОТГОНБАЯР
20.....оны 4 сарын 14

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 17/24

Төрийн банкны Хөвсгөл аймгийн Рашаант сумын тооцооны төвийн барилгын цахилгаан хангамжид зориулж дараах техникийн нөхцөлийг олгож байна.

Шинээр татах кабель шугам болон тоноглолын угсралтыг ЦБД болон ТАД-ын дагуу хийж гүйцэтгэх.

1. 10/0,4кВ-ын КТП-2 дэд станцын 0,4кВ-ын гаргалгааны ЦДАШ-н тохиромжтой тулгуураас салбарлан авч ачаалалд тохирсон хөндлөн огтлолттой 0,4кВ-ын сип кабель, төмөр бетон тулгуур бүхий шугам хэрэглэгчийн байршил хүртэл шинээр барьж ЦЭХ авах.
2. Стандартчилал хэмжил зүйн загварын туршилтанд орж баталгаажуулсан тоолуур бүхий стандартын шаардлага хангасан щитийг ЦДАШ-н хэрэглэгч талын төгсгөлийн тулгуур шон дээр байрлуулах.
3. Тус техникийн нөхцөлөөр 15 кВт хүртэл чадал хэрэглэхийг зөвшөөрнө.
4. Кабель шугамын хөндлөн огтлол, щитэнд тавигдах тоноглолуудын чадлыг тооцоогоор сонгох.
5. Тэжээлийн кабель ямар нэг залгаасгүй байна.
6. Хэрэглэгчийн зэрэглэл-3
7. 0,4кВ-ын ЦДАШ, ЦДКШ-ийн трассыг сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан сумын газрын албатай зөвшилцөж зургаар баталгаажуулах
8. Цахилгаан хангамж тасалдсан тохиолдолд хэрэглэгчийг өмч хөрөнгөд ноцтой хохирол учирч болох онцлогтой хэрэглэгч нь фазын хамгаалалт, хүчдэл тогтворжуулагч, хөдөлгүүрийн хамгаалалт, хүчдэлийн хамгаалалт зэрэг тоног төхөөрөмжийг хамгаалах үндсэн хамгаалалтуудыг суурилуулах.
9. Хэрэглэгч нөөц цахилгаан үүсгүүртэй байх ба автомат асаалтын систем болон АВР-тэй байна. Хүчдэл тасарсан тохиолдолд эргэх хүчдэл орж ирэх боломжгүй байдлаар нэмэлт сэлгэн залгах, салгах тоноглол тавьсан байна.
10. Цахилгаан угсралт, монтажийн ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэж баталгаа гаргуулсан байх.
11. Техникийн комисс ажиллаж дүгнэлт гаргасны дараа тус комиссын шийдвэрийг үндэслэн ЦШС-нд холбоно.
12. ЦДАШ, дэд станцын зураг төсөл боловсруулахдаа Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм /БНбД 11-01-98/ Монгол улсын цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм-д заасны дагуу гүйцэтгэх.
13. Техникийн нөхцөлд заагдсан арга хэмжээг дутуу авсан нөхцөлд ЦЭХ-ээр хангахгүй болно.
14. Хэрэглэгч ЦЭХ хэрэглэсэн төлбөр тооцоог харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх, удаа дараа гэрээний заалт зөрчсөн болон зүй бус хэрэглээ сүлжээнд холбож хэрэглэсэн тохиолдолд техникийн нөхцөл цуцлагдана.
15. Уг техникийн нөхцөлөөр ЦЭХ авч үйл ажиллагаа явуулах хүчинтэй хугацаа техникийн нөхцөл олгогдсон өдрөөс эхлэн 2026 оны 04-р сарын 1 хүртэл байна.
16. Техникийн нөхцөлийн дагуу сүлжээнд холбох хугацаа техникийн нөхцөл олгогдсон өдрөөс эхлэн 2024 оны 11-р сарын 1 хүртэл байна
17. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусах үед сунгуулах ба хаяж үрэгдүүлсэн тохиолдолд шинээр авна.
18. Хүчин чадал нэмэгдүүлэх, өмчлөл өөрчлөгдөх, байршил солигдвол дахин техникийн нөхцөл авна.
19. Техникийн нөхцөлд заагдаагүй ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан тоноглол хэрэглэснээс гарсан гэмтэл саатал хохирлыг техникийн нөхцөл олгосон байгууллага хариуцахгүй.

Техникийн комиссын гишүүд

Ашиглалт засварын инженер **Л.Саруулбаяр**

Ахлах диспетчер **Э.Хоролсүрэн**